



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр.
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69.
<http://www.mmhi.gov.mn>

2021.10.06 № 01/2415
танай 2021.09.21 -ны № 34 -т
2021.09.27 дм/2392

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ӨНӨРБОЛОР ТАНАА**

Таны 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр ирүүлсэн асуулгын дагуу холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.
Хавсралт 5 хуудастай.



Г.ЁНДОН

МЭДЭЭЛЭЛ, ТАНИЛЦУУЛГА

1. Шатахууны хангамжид үүсээд байгаа нөхцөл байдлыг арилгах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон хэвийн тогтвортой байдлыг хэзээ, хэрхэн хангах талаар;

Өнөөгийн байдлаар манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100% импортоор хангаж байгаа ба нийт импортын 95 хувийг ОХУ, 5 хувийг БНХАУ тус тус эзэлж байна.

“Роснефть” НХН болон Монголын шатахуун импортлогч компаниудын хооронд байгуулсан 2023 он хүртэл шатахуун нийлүүлэх урт хугацааны гэрээгээр сар бүрийн захиалгын хамгийн бага хэмжээг тогтоож, нийлүүлэхээр тохиролцсон ба тус гэрээнд АИ-92 шатахууны минимум хэмжээг сард 28 мянган тонн байхаар тусгасан байдаг.

Роснефть компаниас сар бүрийн 26-ны өдөр дараа сард нийлүүлэх шатахууны хил үнийг ирүүлдэг бөгөөд шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүд тус үнэд үндэслэн дараа сард худалдан авах шатахууны захиалгын хэмжээг нийлүүлэгч талд хүргүүлэн харилцан баталгаажуулдаг.

Энэ оны 08 дугаар сарын сүүлээр шатахууны захиалгын хэмжээг баталгаажуулах үеэр Роснефть компани Ангарскийн газрын тос боловсруулах үйлдвэрт ээлжит техникийн засвар, үйлчилгээ хийгдэж байгаа шалтгаанаар 09 дүгээр сард нийлүүлэх АИ-92 автобензиний захиалгын хэмжээг минимум хэмжээнээс 50 хувиар бууруулж, нийлүүлэх болсон талаар импортлогч аж ахуйн нэгжүүдэд мэдэгдсэн байна.

Манай улсын АИ-92 автобензиний сарын дундаж хэрэглээ 38 мянга орчим тонн орчим байдаг бөгөөд дээрх нөхцөл байдалтай холбогдуулан шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүд хэрэглээнд үүсч буй АИ-92 автобензиний зөрүүг БНХАУ-аас хангахаар төлөвлөн, тус улсын Петрочайна интернэшнл компаниас худалдан авах захиалгыг 8 дугаар сарын сүүлчээр өгсөн байна.

Монголын нефть хийн үндэсний ассоциацаас 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 21/42 дугаар албан бичгээр БНХАУ-аас импортлох шатахууны тээвэрлэлтэд дэмжлэг үзүүлэх хүсэлт ирүүлсний дагуу Хятадаас 9 дүгээр сард ачигдах шатахууны тээвэрлэлтийг төмөр замын хуваарьт оруулах, тээвэрлэлтийг саадгүй явуулах асуудлыг “Улаанбаатар төмөр зам” ХНН болон БНХАУ-ын Хөх хотын төмөр замын газарт уламжлан, дэмжлэг үзүүлж ажиллах хүсэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01/2192 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/2240 дугаар албан бичгээр Гадаад Харилцааны сайд Б.Батцэцэг нарт тус тус хүргүүлсэн.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-наас Монгол Улс руу тээвэрлэгдэх шатахуун ачсан 209 вагоны тээврийн асуудлыг хурдавчлах асуудлыг Хятадын талын холбогдох байгууллагад хүргүүлэн, дэмжлэг үзүүлж ажиллах тухай 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А-422 дугаар нот бичгийг БНХАУ-ын Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.

Роснефть компани 09 дүгээр сарын эхээр нийт 7450 тонн АИ-92 автобензин нийлүүлж, үлдсэн 10 гаруй мянган тонныг нийлүүлэх боломжгүй талаар 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр мэдэгдсэн, мөн Хятадын талын нийлүүлэгчээс 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улс руу тээвэрлэгдэх шатахуун ачсан вагоны тээвэрлэлт Хятадын төмөр замын ачаалалтай холбоотойгоор 9 дүгээр сарын төмөр замын хуваарьт ороогүй талаар мэдээ ирүүлсэн зэрэг нь АИ-92 автобензиний хангамж доголдох, нөөц буурах нөхцөл байдалд хүргэсэн.

Иймд Хятад улсаас импортлох шатахууны төмөр замын тээврийг төмөр замын хуваарьт оруулах, тээвэрлэлтийг саадгүй, шуурхай гүйцэтгэх, Замын-Үүд боомтоор яаралтай татан авах асуудлаар Гадаад харилцааны яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яам болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Зам, тээврийн хөгжлийн сайдаас Хөх хотын боловсруулах үйлдвэрээс сар бүр 380-545 вагон, тэр дундаа 09 дүгээр сарын ойрын өдрүүдэд 200 вагонцитерн шатахууныг нэн яаралтай ачуулж, тээвэрлэлтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх хүсэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн 01/123 дугаар албан бичгээр БНХАУ-ын "Хятадын төмөр замууд корпорац"-ийн ТУЗ-ын даргад явуулсан.

Мөн шатахууны хангамж, нийлүүлэлтэд үүсээд байгаа нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулан, Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан.

Үүний үр дүнд Хятадын тал Монгол Улс руу шатахуун тээвэрлэх 200 вагоныг тус улсын 09 дүгээр сарын төмөр замын хуваарьт нэмэлтээр оруулж, шуурхай хамтран ажилласан ба АИ-92 автобензин ачсан эхний ээлжийн 50 вагон 2021.09.26-ны өдөр, хоёр дахь ээлжийн 50 вагон 2021.09.27-ны өдөр, 3 дахь ээлжийн 50 вагон 2021.09.28-ны өдөр, 4 дэх ээлжийн 50 вагон 2021.09.29-ны өдөр тус тус Замын-Үүд боомтоор орж ирсэн ба 4 удаагийн ачилтаар нийт 11000 орчим тонн АИ-92 автобензин импортлоод байна.

Хилээр орж ирсэн шатахууныг шилжүүлэн ачих ажлыг "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ бүх хүчин чадал, нөөц боломжоо дайчлан гүйцэтгэж байгаа ба өнөөдрийн байдлаар нийт 200 вагоныг шилжүүлж ачиж дуусган, төмөр замын хуваарийн дагуу 180 вагоныг Улаанбаатар хот руу явуулсан.

Шатахуун импортлогч ААН-үүд 10 дугаар сард БНХАУ-аас нийт 23500 орчим тонн автобензин, 4800 тонн орчим дизель түлш худалдан авах захиалга өгч нийт 515 вагоны төмөр замын урьдчилсан захиалгын дугаар авснаас Хятадын төмөр зам 316 вагоныг төмөр замын эхний 10 хоногийн хуваарьт оруулсан. Үүнээс эхний 100 вагон буюу 5500 тонн АИ-92 автобензин, 66 вагон буюу 3300 тонн дизель түлш 10 дугаар сарын 4-нд Замын-үүд боомтоор орж ирж, шилжүүлэн ачих ажил хийгдэж байна.

БНХАУ-аас шатахуун импортлох ажлыг зохион байгуулахын зэрэгцээ ОХУ-аас шатахууны нийлүүлэлтийг хэвийн төвшинд хүргэх, нэмэгдүүлэхтэй холбогдуулан "Роснефть" компанитай хийх уулзалтыг 2021 оны 09 дүгээр сарын 22-ний өдрөөс 23-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо зохион байгуулсан.

Оросын талаас 9 сарын багтаан 1575 тонн АИ-92 автобензинийг шуурхай нийлүүлж, 10 дугаар сард 45880 тонн АИ-92 автобензин, нэмэлтээр 9 дүгээр сарын захиалгаас ачигдаагүй үлдсэн 9000 тонн АИ-92 автобензин, 47180 тонн өвлийн дизель түлш, 3020 тонн А-80 автобензин, 2500 тонн АИ-95 автобензин нийт 107580 тонн шатахуун нийлүүлэхээр тохиролцсон. Энэ хүрээнд ОХУ-аас 1575 тонн АИ-92 автобензин 09-р сарын 27-ноос орж ирээд байна.

Эдгээр арга хэмжээний үр дүнд нийт 12500 орчим тонн АИ-92 автобензин импортоор орж ирснээр нөөц дээрх хэмжээгээр нэмэгдэн, тус бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт тогтворжиж борлуулалт, түгээлт хэвийн горимдоо орсон.

2. Газар тариалангийн бүс нутаг /Сэлэнгэ аймаг/-т ургац хураалтын үед бензин, шатахууныг нөөцлөх, хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

Ургац хураалтад ажиллах машин механизм, техник, тоног төхөөрөмжийн ихэнх эь дизель түлшээр ажилладаг.

Улсын хэмжээнд 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар АИ-92 автобензиний үлдэгдлэл нөөц 20000 гаруй тонн болоод байгаа нь ердийн хэрэглээний 15 хоногийн нөөц юм. Бусад төрлийн шатахууны хувьд А-80 автобензин 4,513 тонн буюу 28 хоног, дизелийн түлш 60,850 тонн буюу 25 хоног нөөцтэй байна.

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЛДЭГДЛИЙН МЭДЭЭ /хот, аймгаар/

2021 оны 10 дугаар сарын 05-ны өдөр

№	Бүсийн	Тулгуур	Аймаг, хотын нэр	А-80	АИ-92	АИ-95	АИ-98	ДТ	ТС	Нийт
				ТОНН	ТОНН	ТОНН	ТОНН	ТОНН	ТОНН	ТОНН
1	Баруун бүс	Ховд, Улиастай	Баян-Өлгий	279	629	9	-	2,349	-	3,266
2			Говь-Алтай	101	160	8	-	153	-	422
3			Завхан	52	306	35	-	176	-	569
4			Увс	83	646	28	-	2,242	-	2,999
5			Ховд	86	226	4	-	737	-	1,053
Баруун бүсийн нийт үлдэгдэл				601	1,967	84	-	5,657	-	8,309
6	Хангайн бүс	Хархорин, Эрдэнэт	Архангай	59	126	14	-	108	-	307
7			Баянхонгор	24	116	20	-	145	-	305
8			Булган	136	217	35	-	195	-	583
9			Өвөрхангай	78	140	19	-	130	-	367
10			Орхон	74	236	10	5	406	-	731
11			Сэлэнгэ	122	187	24	-	353	-	686
12			Хөвсгөл	35	108	31	-	105	-	279
Хангайн бүсийн нийт үлдэгдэл				528	1,130	153	5	1,442	-	3,258
13	Төвийн бүс	Зуунмод, Дархан	Төв	104	257	23	-	392	-	776
14			Дархан	247	427	15	4	4,139	-	4,832
15			Говьсүмбэр	79	98	13	-	3,421	-	3,611
16			Дундговь	61	81	12	-	100	-	254
17			Дорноговь	287	678	30	-	6,517	-	7,512
18			Өмнөговь	147	271	5	-	1,190	-	1,613
Төвийн бүсийн нийт үлдэгдэл				925	1,812	98	4	15,759	-	18,598
19	Зүүн бүс	Чойбалсан, Өндөрхаан	Дорнод	402	1,040	43	-	3,677	-	5,162
20			Сүхбаатар	55	104	11	-	209	-	379
21			Хэнтий	127	239	11	-	197	-	574
Зүүн бүсийн нийт үлдэгдэл				584	1,383	65	-	4,083	-	6,115
Улаанбаатар нийт үлдэгдэл				640	5,751	432	20	27,403	514	34,760
Улсын нийт үлдэгдэл				3,284	12,046	838	28	54,343	514	71,053

ОХУ-аас 9 сарын багтаан 1575 тонн АИ-92 автобензинийг шуурхай нийлүүлж, 10 дугаар сард 45880 тонн АИ-92 автобензин, нэмэлтээр 9 дүгээр сарын захиалгаас ачигдаагүй

үлдсэн 9000 тонн АИ-92 автобензин, 47180 тонн өвлийн дизель түлш, 3020 тонн А-80 автобензин, 2500 тонн АИ-95 автобензин нийт 107580 тонн шатахуун нийлүүлэхээр тохиролцсон. Эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний дүнд газрын тосны бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдал хангагдаж, ургац хураалтыг саадгүй явуулах боломж бүрдэнэ.

3. Цар тахлын энэ үед хүнсний болон гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлт, стратегийн бараа бүтээгдэхүүний татан авалтад бензин, шатахууны хомстлоос үүсэх нөлөөллийг бууруулах чиглэлээр улсын хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын талаар;

Гадаад хүчин зүйлсээс хамаарч дотоодын зах зээл дээрх шатахууны хангамж доголдох, үнийн огцом өсөлт бий болох нөхцөл байдалд хүрсэнтэй холбогдуулан манай яамнаас тухайн нөхцөлд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хувилбарыг боловсруулан Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба Засгийн газрын хуралдаанаас өргөн хэрэглээний АИ-92 автобензиний улсын нөөцийг 30 мянган тонноор нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.

Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтран “Шатахууны улсын нөөц бүрдүүлэх, худалдан авах төлбөр тооцоо гүйцэтгэх түр журмыг баталж, худалдан авах үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Улсын нөөцийн 30 мянган тонн АИ-92 автобензинийг Засгийн газрын 2021 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 68 дугаар тогтоолоор баталсан “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу газрын тосны бүтээгдэхүүн импортлогч, бөөний худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр хадгалуулах бөгөөд үүний үр дүнд шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангах, үнийн огцом өсөлтөөс сэргийлэх боломж, нөхцөл бүрдэх юм.

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн хэлбэлзлээс дотоодын зах зээлийг хамгаалах, гадаад хүчин зүйлсийн хамаарлыг багасгах, дунд хугацаанд шатахууны үнийг тогтворжуулах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал буюу шатахууны үнэ тогтворжуулах, эрсдэлийн сан байгуулах асуудлыг Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрийг гаргуулсан ба хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.

Урт хугацаандаа манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээний гадаад хамаарлаас ангижрах хамгийн чухал бөгөөд үр дүнтэй арга хэмжээ бол дотооддоо газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах бөгөөд Монгол Улсын Засгийн газар нь Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж, байгуулах төслийг 2017 оноос эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлж, бүтээн байгуулалтын ажил амжилттай үргэлжилж байна.

Тус үйлдвэр ашиглалтад орсноор стратегийн ач холбогдол бүхий шатахууны хангамжийн найдвартай дотоод эх үүсвэртэй болж, гадаад хүчин зүйлсээс хамаарсан хангамж, чанар, үнийн хэлбэлзэлд өртдөг байдлаас ангижрах, гадаад худалдааны алдагдлыг бууруулах, жил бүр шатахууны импортод зориулан гадагш урсаж буй 1 тэрбум гаруй ам. долларын урсгалыг багасгах, инфляцыг тогтворжуулах, манай улсад хүнд үйлдвэр тэр дундаа нефть химийн үйлдвэрийг суурь тавигдаж, өргөжин хөгжих боломж бүрдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон чухал ач холбогдолтой юм.

4. Цаашид бензин, шатахууны хомстол нь үнэд нөлөөлөх эсэх, үнийг тогтворжуулах ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж буй талаар тодорхой хариулт ирүүлнэ үү;

Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн хэлбэлзлээс дотоодын зах зээлийг хамгаалах, гадаад хүчин зүйлсийн хамаарлыг багасгах, дунд хугацаанд шатахууны үнийг тогтворжуулах чиглэлээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал буюу шатахууны үнэ тогтворжуулах, эрсдэлийн сан байгуулах асуудлыг Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрийг гаргуулсан ба хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ